

ДЭЛХИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ХӨГЖЛИЙН ЧИГ ХАНДЛАГА 2020

III. Болормаа *

Д

элхийн нэгдүгээр дайнаас хойш дэлхийн аялал жуулчлал маш эрчимтэй хөгжиж эхэлсэн ба 1919 онд Газрын дундад тэнгисийн орнууд голлож Олон улсын жуулчлалын агентлагийг Парис хотноо байгуулснаар Дэлхийн аялал жуулчлалын байгууллаг (ДАЖБ)-ын эхлэл тавигдсан. Олон улсын аялал жуулчлын хөгжил цэцэглэлтийг 1950 оноос эхэлсэн гэж үздэг бөгөөд ДАЖБ-ын эрхэм зорилт нь аялал жуулчлалыг хөгжүүлэх замаар дэлхийн эдийн засгийг хөгжүүлэх, олон улсын харилцан ойлголцлыг бэхжүүлэх, энх тайвныг сахин хамгаалах, хүний эрхийг дээдлэн хүндэтгэж хамгаалахад нөлөөлөх явдал юм.

ДАЖБ-ын Ерөнхий Ассамблейн шийдвэрийг амьдралд хэрэгжүүлэх зорилгоор Европ, Америк, Африк, Ойрхи Дорнод, Ази, Зүүн Ази, Номхон Аялайн гэсэн бүс нутгийн 6 комиссоор үйл ажиллагаа зохион байгуулан явуулж байна.

Өнөөдөр ДАЖБ нь НҮБ-ын биеэ даасан төрөлжсөн агентлагийн статустайгаар 141 орон, 7 бүс нутгийг төлөөлсөн 350 гаруй гишүүдтэй.¹ Түүнчлэн тус байгууллагад аялал жуулчлалын төрийн болон төрийн бус, боловсрол, эрдэм шинжилгээ, хувийн хэвшлийг төлөөлсөн байгууллагууд хамрагддаг бөгөөд эдгээр комиссууд нь бүс нутгийн хэмжээнд аялал жуулчлалын салбарын хөгжлийн талаар хамтран ажиллах, хүний нөөцийг хөгжүүлэх, аялал жуулчлалын тогтвортой хөгжлийг хангах, үйлчилгээний чанарыг дээшлүүлэх, салбарын статистик болон эдийн засгийн дүн шинжилгээг боловсронгуй болгон зах зээлийг судлах ба сурталчилгаа хийх, харилцан мэдээлэл солилцох зэрэг үндсэн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг билээ.²

2003 онд Дэлхийн аялал жуулчлалын салбарын хөгжилд Иракийн хямрал, дэлхийн эдийн засгийн тогтворгүй байдал, Азийн ханиад өвчин зэрэг томоохон бэрхшээл учирч 2002 онтой харьцуулахад аялал жуулчлал дэлхийн хэмжээнд 1,2 хувиар багассан нь дэлхийн аялал жуулчлалын түүхэнд нэг жилийн дотор гарсан хамгийн их уналт гэж тодорхойлсон байна.

2003 оны эхний хагаст аялал жуулчлал Ази, Номхон далайн бүс нутагт дундаж үзүүлэлтээс 2 дахин буурсан ч сүүлийн хагаст аялал жуулчлалын үзүүлэлт нэмэгдэх хандлагатай болсон байна. Дэлхийн аялал жуулчлал 2003 онд Европын баруун хэсэгт 3,7 сая аяллаар багассан байхад Төв болон Зүүн хэсэгт 2002 оны үзүүлэлтүүдийг давсан байна. Ази Номхон далайн бүс нутгийн

* МУИС, ОУХС-ийн багш, докторант

¹ <http://www.world-tourism.org>


² <http://www.unwto.org>

хэмжээнд 9 хувиар аяллын тоо буурсан байна. Үүнээс Зүүн хойд Азийн бүс нутаг 9 хувиар, Зүүн өмнөд Азийн хэсэг 16 хувиар аяллын тоо багассан байхад Өмнөд Азид аялал 17 хувиар өссөн нь энэ бүс нутагт эдийн засгийн өсөлт нэмэгдэж, худалдаа арилжаа ихээхэн либералчлагдаж байгаатай холбоотой юм.³

Дэлхийн аялал жуулчлал 2020

Дэлхийн аялал жуулчлалын байгууллага нь шинэ мянганы эхний 20 жилийн дэлхийн аялал жуулчлалын хэтийн төлвийг 1995-2020 оныг хамруулан 25 жилийн урт хугацааны урьдчилсан тооцоог “Дэлхийн Аялал жуулчлал 2020” нэртэйгээр гаргасан бөгөөд уг тооцоогоор 2020 он гэхэд олон улсын жуулчдын тоо 1,6 тэрбумд хүрэх бөгөөд үүний 1,2 тэрбум нь өөрийн бүс нутаг дотроо, 378 сая нь хилийн чандад аялах жуулчид байх юм байна. (Хүснэгт-1)⁴

(Хүснэгт-1)



Нийт жуулчлан ирэгсдийг бүс нутгаар авч үзвэл 2020 он гэхэд хамгийн их жуулчин хүлээн авах 3 бүс нутаг нь Европ (717 сая жуулчин), Зүүн Ази, Номхон далай (397 сая), Америк (282 сая) байх бөгөөд Африк, Ойрхи Дорнод, Өмнөд Азийн бүс нутгууд удаах байруудад орж байна. (Хүснэгт-2)

Зүүн Ази, Номхон далай, Ази, Ойрхи Дорнод, Африкийн бүс нутгуудыг дэлхийн дундаж 4,1 хувьтай харьцуулахад жилд 5-аас дээш хувийн өсөлттэй, харин илүү хөгжингүй бүс нутгууд болох Европ, Америк нь дунджаас доогуур өсөлттэй байх тооцоотой байна. Европ нь хэдийгээр 1995 онд нийт жуулчдын 60 хувийг хүлээн авч байсан боловч 2020 онд 46 хувь болж буурах ч жуулчлалын хамгийн том төв хэвээр байх төлөвтэй байна.⁵

³ Compendium of Tourist Statistics, 2005, WTO

⁴ Lindsay W. Turner and Stephen F. Witt "Tourism Forecast" 2007

⁵ Asia Pacific Tourism Forecast, 2007, PATA

2010-2020 онд бүс нутаг дотроо аялах жуулчдын тоо жилд 3,8 хувиар өсөх бол хилийн чандад аялагчдын тоо илүү хурдацтай буюу жилд 5,8 хувь өснө гэж тооцоолж байгаа бөгөөд 1995 онд 82:18 байсан бүс нутгийн доторх болон хилийн чандад аялагчдын харьцаа нь 2020 он гэхэд 76:24 болж өөрчлөгдөх төлөвтэй байна.

Аялал жуулчлал ба дэлхийн эдийн засаг

Аялал жуулчлал нь ард түмнийг харилцан ойлголцуулахаас гадна нийгэм-эдийн засаг, шинжлэх ухаан, соёлын хамтын ажиллагааг өргөжүүлж, улс орны нийгэм-эдийн засгийн хөгжилд чухал үүрэг гүйцэтгэдэг үйлдвэрлэлийн салбар юм.

(Хүснэгт-2)⁶

	Суурь он		Урьдчилсан тооцоо		Зах зээлд эзлэх хувь (%)		Жилийн дундаж өсөлт (%)
	1995		2010	2020			
	Сая			1995	2020	1995-2020	
Дэлхий	565	1006	1561	100	100	4.1	
Африк	20	47	77	3.6	5.0	5.5	
Америк	110	190	282	19.3	18.1	3.8	
Зүүн Ази Номхон Далай	81	195	397	14.4	25.4	6.5	
Европ	336	527	717	59.8	45.9	3.1	
ОйрхиДорнод	14	36	69	2.2	4.4	6.7	
Өмнөд Ази	4	11	19	0.7	1.2	6.2	

Сүүлийн жилүүдэд дэлхийн хүн амын амьжиргааны түвшин дээшилж улмаар чөлөөт цагаа аялан зугаалж, амарч өнгөрөөх сонирхол нэмэгдсэн нь аялал жуулчлалын үйлдвэрлэлийг дэлхийн үйлдвэрлэлийн томоохон салбар болж хөгжүүлэх нэг нөхцлийг бүрдүүлж байна. Аялал жуулчлалын эрэлт нь юуны өмнө үйлдвэрлэлийн гол зах зээлүүдийн эдийн засгийн нөхцөл байдлаас хүчтэй хамааралтай байдаг. Эдийн засаг өсөхөд хэрэглээний орлогын түвшин ч мөн дагаад өсдөг. Улс орнуудад, тэр дундаа шинээр бий болж байгаа эдийн засгийн салбарт хүмүүс өөрийн орлогынхоо багагүй хэсгийг аялал жуулчлалд зарцуулдаг бөгөөд эдийн засгийн нөхцөл байдал сайжрах нь аялал жуулчлалын зардлыг бууруулахад хүргэнэ.


Өөрөөр хэлбэл олон улсын жуулчдын өсөлт нь дотоодын нийт бүтээгдэхүүнээр хэмжигдэх эдийн засгийн өсөлтөөс илүү байдаг байна. Дэлхийн эдийн засгийн өсөлт 4 хувиас дээш байсан жилүүдэд аялал жуулчлалын өсөлт илүү өндөр байх хандлагатай байдаг ба ДНБ-ний өсөлт 2 хувиас бага болоход

⁶ Lindsay W. Turner and Stephen F. Witt "Tourism Forecast" 2007

аялал жуулчлалын өсөлт ч мөн буурдаг. Жишээлбэл: ДНБ нь 3,5 хувийн өсөлттэй байхад аялал жуулчлал үүнээс дунджаар 1,3 дахин их өссөн байна. 1975-2000 онуудад аялал жуулчлал жилд дунджаар 4,6 хувь өсч байжээ (Хүснэгт-3)⁷.

(Хүснэгт-3)

Эдийн засгийн өсөлт (ДНБ) ба Олон улсын жуулчдын тоо



Дүгнэлт

ДАЖБ-аас гаргасан “Шинэ Мянганы эхний 20 жилийн дэлхийн аялал жуулчлалын хэтийн төлөв 2020” тооцоогоор нийт жуулчдын тоо 1.6 тэрбумд хүрэх бөгөөд 2010-2020 онд хилийн чанадад аялагчид 1995 онтой харьцуулахад 5,8 хувиар, дотооддоо жуулчлагчдын тоо 3.8 хувиар тус тус нэмэгдэх хандлагатай байна.

1995 онд жилийн чанадад аялагчдын 60 орчим хувь буюу хамгийн их хэмжээний жуулчид хүлээн авсан бүс нутаг Европ байсан бөгөөд 2020 онд ч мөн хэвээр байх төлөвтэй байна.

⁷ Clifton, P., Nguyen, H. And Nutt, S., Market research: Using Forecasting in Tourism, 2000